



Оюу Толгой ХХК

Орон нутгийн харилцаа

Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлыг хангах удирдлагын төлөвлөгөө

Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-PLN-0001-М	Хувилбар: 1.3

АГУУЛГА

1	ТАНИЛЦУУЛГА	4
1.1	Зорилго	4
1.2	Хэрэглээ	4
1.3	Эхлэх огноо	4
1.4	Эрх мэдэл ба удирдлага	4
2	ХАМРАХ ХҮРЭЭ	5
2.1	Удирдлагын төлөвлөгөөний хамрах хүрээ	5
2.2	Бусад удирдлагын төлөвлөгөөтэй давхцах байдал	5
3	ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА	6
3.1	Удирдлагын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гүйцэтгэх гол үүрэг, хариуцлага	6
3.2	Гол уялдаа холбоо	6
4	ТӨСЛИЙН СТАНДАРТУУД	7
4.1	Монгол улсын холбогдох стандартууд	7
4.2	БОНБНУ-ний шаардлага	8
4.3	Монгол улсын засгийн газрын өмнө хүлээсэн бусад үүрэг амлалт, шаардлагууд	8
4.4	Олон улсын холбогдох стандарт, удирдамжууд	9
4.5	Оюу толгой, Рио Тинто компаниудын холбогдох стандартууд	12
4.6	Оюу толгой компани мөрдөхөөр үүрэг амлалт авсан салбарын бусад удирдамжууд ...	16
4.7	Төслийн холбогдох стандартуудын хураангуй	16
5	НӨЛӨӨЛӨЛ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ БА УДИРДЛАГЫН ХЯНАЛТУУД	17
5.1	Хураангуй	17
5.2	Төлөвлөгөөний зорилго, зорилт	23
5.3	Орон нутгийн болон бусад гол оролцогч талууд	24
5.4	УДИРДЛАГЫН ХЯНАЛТУУД	26
6	ХЭРЭГЖИЛТИЙН ХУВААРЬ	33
6.1	Удирдлагын төлөвлөгөөний хяналт шинэчлэлт	33
6.2	Хэрэгжүүлэхээр товлосон хугацаа	33
7	ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ	34
7.1	Хяналт шинжилгээний шаардлагуудын тойм	34
7.2	Гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүд	34
7.3	Хяналт шинжилгээний үндсэн үйл ажиллагаа	35
8	СУРГАЛТ	36
9	АУДИТ БА ТАЙЛАГНАЛ	37
9.1	Аудит	37
9.2	БАРИМТ БИЧГИЙН ГАДААД АУДИТ	37
9.3	БАРИМТ БИЧГИЙН ХАДГАЛАЛТ	37
10	БАРИМТ БИЧГИЙН ХЯНАЛТ	38

Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-PLN-0001-М	Хувилбар: 1.3

ХҮСНЭГТҮҮД

Хүснэгт 1: Гол үүрэг, хариуцлага	6
Хүснэгт 2: Удирдлагын үндсэн хяналтууд	23
Хүснэгт 3: Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын хөтөлбөрийг хэрэгжүүлэх гол үе шатууд 2018-2020 он.....	27
Хүснэгт 4: Гүйцэтгэлийн үндсэн үзүүлэлт, хяналт шинжилгээний үйл ажиллагаа – Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал ...	28
Хүснэгт 5: Хяналт шинжилгээний үндсэн арга хэмжээ	29

Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-ПЛН-0001-М	Хувилбар: 1.3

1 ТАНИЛЦУУЛГА

1.1 Зорилго

Удирдлагын төлөвлөгөөний зорилго нь

- Удирдлагын төлөвлөгөөний хамрах хүрээг тодорхойлж, хэрэгжилттэй холбоотой удирдлагын харилцааг харуулах
- Үүрэг хариуцлагыг тодорхойлох
- Энэхүү удирдлагын төлөвлөгөөнд хамаарах төслийн стандартуудыг тодорхойлох;
- Энэ удирдлагын төлөвлөгөөнд хамаарах төслийн хариуцах асуудлууд, үйл ажиллагааны дүрэм, журмыг тодорхойлох
- Гүйцэтгэлийн гол үзүүлэлтүүдийг оролцуулсан мониторинг хийх болон тайлагнах журмыг тодорхойлох
- Сургалтын шаардлагыг тодорхойлох
- Туслах баримт бичиг болон мэдээллийн лавлагаа авах мэдээллийг харуулах.

1.2 Хэрэглээ

Энэхүү удирдлагын төлөвлөгөөнд тусгагдсан шаардлагууд нь Оюу Толгойн бүх үйл ажиллагаанд хамаарна.

Тус удирдлагын төлөвлөгөөг Рио Тинто компанийн Орон нутаг, нийгмийн асуудал эрхэлсэн захирлын хариуцдаг 2015 оны 4-р сарын 1-ний өдрийн Орон нутгийн стандартад тулгуурлаж боловсруулсан болно. Рио Тинто компанийн Орон нутгийн стандартын аливаа өөрчлөлт нь Оюу толгой компанийн удирдлагын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулахад хүргэж болно.

1.3 Эхлэх огноо

Тус удирдлагын төлөвлөгөө 2013 оны 9-р сарын 1-нээс хүчин төгөлдөр болно.

1.4 Эрх мэдэл ба удирдлага

Оюу Толгой компанийн Гүйцэтгэх хороо 2013 оны 9 сарын 1-ний өдөр энэхүү удирдлагын төлөвлөгөөг батлав.

Оюу Толгой компанийн Орон нутгийн харилцааны хэлтсийн ерөнхий менежер тус удирдлагын төлөвлөгөөг хадгалах, удирдах ажиллагааг гүйцэтгэнэ. Төслийн зураг төсөл, журам өөрчлөгдсөнийг тусгах үүднээс ойрхон давтамжтай шинэчлэх шаардлага гараагүй нөхцөлд төлөвлөгөөнд өөрчлөлт, шинэчлэл оруулах шаардлагатай эсэхийг тодорхойлох зорилгоор тус удирдлагын төлөвлөгөөг хоёр жил тутам хянаж үзнэ. Тус удирдлагын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах аливаа хүсэлтийг тухайн албан тушаалтанд тавих ба төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах журамд заасны дагуу хянуулж батлуулна.

Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-PLN-0001-М	Хувилбар: 1.3

2 ХАМРАХ ХҮРЭЭ

2.1 Удирдлагын төлөвлөгөөний хамрах хүрээ

Энэхүү удирдлагын төлөвлөгөө нь гүйцэтгэгчдийн үйл ажиллагааг оролцуулсан Оюу толгой компанийн бүх үйл ажиллагаанд хамаарна. Гүйцэтгэгчдийг оролцуулан ОТ-н бүх ажилтан хэрэгжилтийг хариуцна. Гүйцэтгэгчдийн хэрэгжилтийг Гүйцэтгэгчдийн удирдлагын тогтолцоо баримт бичигт тусгасан болно. (ОТ-07-PLN-0001-Е). Удирдлагын төлөвлөгөөнд тусгасан удирдлагын хяналт нь Төслийн талбай дах хэрэгжилтийг тодорхойлно.

2.2 Бусад удирдлагын төлөвлөгөөтэй давхцах байдал

Энэхүү удирдлагын төлөвлөгөө нь Байгаль орчин, нийгмийн удирдлагын төлөвлөгөөнд (БОНУТ) (ОТ-10-PLN0003-Е) тусгагдсан бөгөөд Оюу толгой төслийн Үйл ажиллагааны удирдлагын багц төлөвлөгөөний нэг хэсэг мөн.

Энэхүү удирдлагын төлөвлөгөө нь орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдалд хамааралтай бусад удирдлагын төлөвлөгөөтэй давхцаж, харилцан уялдаа холбоотой байна. Үүнд:

- Агаар мандалд ялгаруулах хийн хаягдлын удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-Е2-PLN-0001-Е), тухайлбал ОТ-н үйл ажиллагаанаас үүссэн тоосны нөлөөллийг зохицуулахтай холбоотой;
- Дуу шуугиан, чичиргээний удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-Е6-PLN-0001-Е), тухайлбал ОТ-н үйл ажиллагаанаас гарах дуу шуугиан нөлөөллийг зохицуулахтай холбоотой;
- Аюултай материал, эрдсийн бус хог хаягдлын удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-Е15-PLN-0001-Е), тухайлбал орон нутгийн иргэдийг аюултай хог хаягдлын нөлөөллөөс хамгаалахтай холбоотой
- Усны нөөцийн удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-Е11-PLN-0001-Е), тухайлбал ундны усан хангамжийг хамгаалахтай холбоотой;
- Уурхайн хаалтын төлөвлөгөө (ОТ-10-Е14-PLN-0002-Е), тухайлбал уурхайн үйл ажиллагаа зогсох үед үлдэж буй бодит аюулаас орон нутгийн иргэдийг хамгаалахтай холбоотой;
- Хүн амын шилжилт хөдөлгөөний удирдлагын төлөвлөгөө (ОТ-10-PLN-0007-Е), тухайлбал Ханбогд сумын нутагт Оюу Толгой компанийн ажилчид болон ажил хайгч иргэдийн шилжин суурьшилтаас гарах сөрөг үр дагаварыг бууруулахтай холбоотой;
- Газар хөндөх зөвшөөрөл олгох журам - тухайлбал эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх тоос шороотой холбоотой газар хөндөлтийг бууруулахтай холбоотой;
- Тээврийн удирдлагын төлөвлөгөө - тухайлбал замын ослыг бууруулах, тоос шороог багасгах, замын хөдөлгөөн, эрсдэлийн талаарх олон нийтийн ойлголт, ухамсарыг нэмэгдүүлэхтэй холбоотой;
- Олон талт хамтын ажиллагааны төлөвлөгөө -тухайлбал нийтийн эрүүл мэндийн талаар олон нийтийн ойлголт, ухамсарыг нэмэгдүүлэхтэй холбоотой;
- Ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөө - тухайлбал осол гарах нөхцөлд олон нийтийн бэлэн байдалдтай холбоотой;
- Хөдөлмөр эрхлэлтийн удирдлагын төлөвлөгөө (HR-10-PLN-0001-Е), тухайлбал ОТ компанийн ажилчдын зан үйлтэй холбоотойгоор;

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-PLN-0001-М	Хувилбар: 1.3

- Аюулгүй байдал, хүний эрхийн удирдлагын төлөвлөгөө (ОТ-12-PLN-0013-Е), тухайлбал харуул хамгаалалтын ажилтнуудын зан үйл, удирдлага зохицуулалттай холбоотой.

3 ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

3.1 Удирдлагын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гүйцэтгэх гол үүрэг, хариуцлага

Энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гүйцэтгэх үндсэн үүрэг болон хариуцлагыг доор тоймлон харуулав.

Хүснэгт 1: Гол үүрэг, хариуцлага

Үүрэг	Хариуцлага
Оюу Толгой компанийн Нийгмийн харилцааны Ерөнхий менежер	Төлөвлөгөөний хамрах хүрээ, хэрэгжилтийн ерөнхий хариуцлага. Энэ төлөвлөгөөний боловсруулалт, хяналт шинжилгээ, өөрчлөлт оруулах.
Оюу Толгой компанийн Орон нутгийн түншлэл, тусламж хариуцсан Менежер	Төлөвлөгөөний гүйцэтгэлд дэмжлэг үзүүлэх. Үйл ажиллагааны хэрэгжилтийг удирдан зохицуулах.
Оюу толгой компанийн Орон нутгийн харилцааны хэлтсийн ажилтан	Энэ төлөвлөгөөг цаг тухайд нь хэрэгжүүлж, гүйцэтгэгч байгууллага болон бусад оролцогч талуудтай хамтран ажиллах Төлөвлөгөөний хэрэгжилт

Одоогоор төслийн нөлөөллийн бүсэд амьдарч буй орон нутгийн иргэдийн эрүүл мэндийг сайжруулахаар олон байгууллага ажиллаж байна. Үүнд Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (ДЭМБ), Монгол улсын Эрүүл мэндийн яам, НҮБ-ын Хүн амын сан, Австралийн элчин сайдын яам, Өмнөговь аймгийн Эрүүл мэндийн газар болон сумдын эрүүл мэндийн төвүүд, ТББ, олон нийтийн байгууллагууд багтана. Тус удирдлагын төлөвлөгөөнд тодорхойлсноор Оюу толгой компани орон нутгийн иргэдийн эрүүл мэндийг хамгаалж, сайжруулахын тулд эдгээр түнш байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

3.2 Гол уялдаа холбоо

Энэхүү удирдлагын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дараах албан тушаалтнууд голлон оролцоно (ө.х.Тус удирдлагын төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгүүдийг хэрэгжүүлэх үүрэгтэй)

- Байгаль орчин, уурхайн талбайн гаднах аюулгүй ажиллагаа, аюулгүй байдалтай холбоотойгоор Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчин, аюулгүй байдлын баг;
- Дэд бүтэц, үйлчилгээ хариуцсан Ерөнхий менежер;
- Хөдөлмөрийн удирдлагатай холбогдуулан Хүний нөөцийн баг.

Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-PLN-0001-М	Хувилбар: 1.3

4 ТӨСЛИЙН СТАНДАРТУУД

Төслийн бүх үйл ажиллагаанд холбогдох стандартуудыг ("Төслийн стандартууд") баримтлан ажиллах ёстой. Үүнд дараах стандартууд багтана:

- Монгол улсын холбогдох стандартууд;
- БОНБНУ-ний шаардлагууд;
- Монгол улсын төрийн байгууллагуудын бусад журам, шаардлага;
- Зээлдүүлэгч байгууллагуудын холбогдох стандарт, удирдамжууд;
- Хүний эрх ба аюулгүй байдлыг хангах тухай сайн дурын зарчмууд;
- Рио Тинто компанийн холбогдох стандартууд; ба
- Оюу толгой компанийн мөрдөхөөр үүрэг амлалт авсан салбарын бусад удирдамжууд.

4.1 Монгол улсын холбогдох стандартууд

Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдалтай холбоотой үндэсний гол хууль тогтоомж болох Ариун цэврийн тухай, Ахуйн болон үйлдвэрийн гаралтай хог хаягдлыг зохицуулах хуулиудыг доор тоймлон өгүүлэв.

Эрүүл ахуйн тухай хууль (2016 оны 2 сарын 4-нд 1 хүчин төгөлдөр болсон)

Энэ хуулийн зорилт нь хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүрээлэн байгаа орчны хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах, арилгахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Энэхүү хуулинд дараах асуудлыг хамруулсан.

- ахуйн болон ундны усны хангамж;
- тоосжилт, утаа, бохирдол зэрэг агаарын чанарын хяналт;
- хөрсний эрүүл ахуй, хог хаягдлын устгал, бохир усны байгууламж, усны нүх болон бие засах газрууд;
- эмнэлгийн хог хаягдал, цацраг идэвхит болон химийн хорт бодисын устгал;
- олон нийтэд зориулсан орон сууц болон байгууламжуудын барилгын ажил;
- химийн хорт бодис болон ионжуулагч цацраг ашиглах;
- дуу шуугиантэй эсвэл доргион, цахилгаан соронзон орон эсвэл радио долгионы нөлөөлөл бүхий орчин дахь үйл ажиллагаа;
- хүнсний бүтээгдэхүүн боловсруулах, хэрэглэх; ба
- бараа бүтээгдэхүүн, технологийн импорт.

Энэхүү хуулийн дагуу бизнесийн байгууллагууд нь дараах үүрэг хүлээнэ.

- Бизнесийн үйл ажиллагаандаа мөрдөх, түүнчлэн ажилчдаа сургах;
- Хүний эрүүл мэнд, байгаль орчинд хортой нөлөө үзүүлэх аливаа нөхцөл байдал үүссэн тохиолдлыг мэргэжлийн хяналтын байгууллагад мэдээлэх;
- Ажилтнууддаа ариун цэвэр сахих, эрүүл мэндээ хамгаалах, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгааг явуулах; ба
- Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах.

Хог хаягдлын тухай хууль (2017 оны 5-р сарын 17-нээс хүчин төгөлдөр болсон)

Энэ хуулийн зорилт нь хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, хог хаягдлыг эдийн засгийн

Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-ПЛН-0001-М	Хувилбар: 1.3

эргэлтэд оруулж, байгалийн нөөц баялгийг хэмнэх, иргэдийн хог хаягдлын талаархи боловсролыг дээшлүүлэх зорилгоор хог хаягдлыг бууруулах, ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, экспортлох болон аюултай хог хаягдлыг импортлох, хил дамжуулан тээвэрлэхийг хориглохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Уг хуулинд агаар мандал, усан орчин, цацраг идэвхит хог хаягдлаас бусад бүх төрлийн хог хаягдалтай холбогдсон харилцааг хамруулна.

Энэхүү хуулийн дагуу бизнесийн байгууллагууд нь дараах үүрэг хүлээнэ.

- гарсан хог хаягдлыг төрөлжүүлэн ангилж хог хаягдал хадгалах түр цэгт хаях, эсвэл хог дахин ашиглах байгууллагад шилжүүлэх, үйл ажиллагаанаас гарсан хог хаягдлын талаар төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудад үнэн зөв мэдээлэл өгөх ;
- хог хаягдлын талаарх дүрэм, журам, стандартуудыг мөрдөх;
- мэргэжлийн байгууллагуудаас хог хаягдлын удирдлагын талаарх техникийн туслалцаа, зөвлөгөө авах;
- үйл ажиллагаандаа аюулгүй ажиллагааны стандартыг мөрдөх ба хог хаягдал ангилах талаарх хэрэгцээтэй мэдлэгийг ажилчиддаа олгох;
- хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудтай гэрээ байгуулсны үндсэн дээр ажиллах ба гэрээний биелэлтийг мөрдөн ажиллах;
- иргэн, аж ахуйн нэгж, байгуулага нь өөрийн эзэмшиж буй барилга байгууламжийг барих, буулгах, засварлахад гарах хог хаягдлыг цуглуулах ба тээвэрлэх талаар урьдчилан гэрээ байгуулан, зохих төлбөрийг төлөн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, булах эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгуулагад шилжүүлнэ.

4.2 БОНБНУ-ний шаардлага

ОТ төсөлд ирүүлсэн БОНБНУ болон холбогдох Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнүүдэд орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдалтай шууд холбоотой тодорхой шаардлагууд байхгүй байна.

4.3 Монгол улсын засгийн газрын өмнө хүлээсэн бусад үүрэг амлалт, шаардлагууд

Монгол улсын төрийн байгууллагуудын тавих шаардлагыг тодорхойлсон үндсэн баримт бичиг нь Оюу толгой төслийн Хөрөнгө оруулалтын гэрээ (2009 оны 10-р сарын 6-нд байгуулсан) юм. Хөрөнгө оруулалтын гэрээний дөрөвдүгээр бүлэгт (Бүс нутгийн хөгжил) Монгол улсын Засгийн газар нь ОТ, Засгийн газар, орон нутгийн удирдах байгууллага, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагууд, Өмнийн говийн бүс нутагт чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг хандивлагч болон олон улсын санхүүгийн байгууллагуудын төлөөлөл бүхий Өмнийн говийн бүсийн хөгжлийн зөвлөл байгуулах тухай орсон байдаг. Үүнд дараах байдлаар заажээ.

* Зөвлөл нь Өмнийн говийн бүс, орон нутгийн хөгжлийн стратеги, төлөвлөгөө болон төсвийг боловсруулах, санхүүжүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулахад Засгийн газарт дараах чиглэлээр туслалцаа үзүүлнэ.

* Орон нутгийн болон бүсийн хөгжил болон ил тод, хариуцлагатай засаглалыг дэмжих;

* Хүн амын шилжилт хөдөлгөөнийг зохицуулах;

Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-ПЛН-0001-М	Хувилбар: 1.3

* Хот төлөвлөлт, хот байгуулалт, түүний дотор эрчим хүч, зам харилцаа, усан хангамж, дулаан, бохир усны асуудлыг шийдвэрлэх;

* Албан болон албан бус боловсрол, түүний дотор англи хэлний сургалт, тусгай мэргэжлийн сургалт явуулах;

* Хүн амын эрүүл мэндэд анхаарлаа хандуулах, оношлогооны төв байгуулах, соёл урлагийн байгууллагууд, биеийн тамир, спортын байгууламжийг барих, мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулах;

* Орон нутгийн засаг захиргаа болон иргэний нийгмийн чадавхийг дэмжих.

4.4 Олон улсын холбогдох стандарт, удирдамжууд

Олон улсын санхүүгийн корпораци (ОУСК), Европын сэргээн босголт хөгжлийн банкны (ЕСБХБ) тавьсан стандартуудыг Оюу Толгой компани хэрэгжүүлэх болно.

Олон улсын санхүүгийн корпораци

ОУСК-ын Нийгэм ба байгаль орчны тогтвортой байдлын Гүйцэтгэлийн стандартууд нь орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа ба аюулгүй байдлын асуудалд холбогдолтой зөвлөмжүүдийг тусгасан байдаг. (**Гүйцэтгэлийн стандарт 4**).¹ Оюу Толгой компани ОУСК-ын гүйцэтгэлийн стандарт 4-ийг мөрдөж ажиллана. Дараах үндсэн шаардлагууд орсон байдаг:

- Төслийн зураг төсөл, барилга, ашиглалт болон төслийн хаалтын үеэр нөлөөлөлд өртсөн иргэдийн эрсдэл болон нөлөөллийг үнэлэх;
- Төслийн үйл ажиллагаа орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа ба аюулгүй байдалд эрсдэл учруулах нөхцөлд нутгийн иргэдэд энэхүү эрсдэл болон сөрөг нөлөөллийг ойлгуулах үүднээс Үйл ажиллагааны төлөвлөгөөг нээлттэй байлгах;
- Төслийн зураг төсөл, барилга, ашиглалт болон хаалтын үе шатанд үйлдвэрлэлд ашиглаж буй олон улсын сайн туршлагыг баримтална. Байгалийн болзошгүй аюулд өртөх байдлыг онцгой анхаарах;
- Төслийн үйл ажиллагааны улмаас хөрс болон гүний усанд сөрөг нөлөөлөл учруулахаас зайлсхийх;
- Түр болон байнгын ажиллах хүчнээр дамжин халдварт өвчин тархах эрсдэлийг багасгах;
- Төслийн үйл ажиллагаанаас үүсэх эрсдэл болон нөлөөллийг үнэлж, орон нутгийн иргэдийн зан заншилд нийцсэн байдлаар мэдээлэх. Орон нутагт үүсч болзошгүй онцгой нөхцөл байдлыг мөн тусгах; ба
- Үндсэн болон гэрээт ажилчид аюулгүй байдлыг хангах ажлыг гүйцэтгэх тохиолдолд уурхайн талбайд болон талбайн гадна байгаа хүмүүст учирч болзошгүй эрсдлийн үнэлгээг хийх зэрэг тус тус орно.

¹ Олон улсын санхүүгийн корпораци *Байгаль орчин, нийгмийн тогтвортой байдлын гүйцэтгэлийн стандартууд*; Гүйцэтгэлийн стандарт 4 Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдал 2006 оны 4-р сарын 30.

Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-PLN-0001-M	Хувилбар: 1.3

ОУСК-ийн *Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны удирдамжид* орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын асуудлыг тусгасан байдаг.² Удирдамж нь дараах зүйлтэй холбоотой асуудалд чиглэнэ.

- Усны чанар болон хүртээмж – нийтийн буюу хувийн эзэмшил эсэхээс үл хамааран усны эх үүсвэрийг хамгаалах ба гадаргуун болон гүний усны нөөцийн чанар ба хүртээмжид сөрөг нөлөөлөл үзүүлэхээс урьдчилан сэргийлэх;
- Төслийн дэд бүтцийн аюулгүй байдал – төслийн барилга байгууламжуудад нэвтрэх үед иргэдэд учирч болзошгүй аюулыг багасгаж, осол эсвэл алдаа гарах эрсдлийг багасгах боломжийг тодорхойлох зорилготой аюулын дүн шинжилгээ хийх;
- Амь насны болон галын аюулгүй байдал – шинэ барилга байгууламжуудын зураг төсөл, барилга болон ашиглалт нь барилгын дүрэм журам, галын зохицуулалт, хуулийн/даатгалын шаардлага хангасан байх ба олон улсаар хүлээн зөвшөөрөгдсөн Амь насны болон галын аюулгүй байдлын стандартыг (ГТБААБС) мөрдөнө. Гал түймрээс урьдчилан сэргийлэх, аваарын гарц (онцгой байдал үүссэн үед аюулгүй нүүлгэн шилжүүлэлтийн арга хэмжээг боловсруулах), гал аюулыг илрүүлэх болон дохиоллын систем, онцгой байдлын үед авах арга хэмжээний төлөвлөгөө зэрэг нь амь насны болон галын аюулгүй байдлыг хангах чухал бүрэлдэхүүн хэсгүүд юм;
- Замын хөдөлгөөний аюулгүй байдал – замын хөдөлгөөний ослоос урьдчилан сэргийлэх, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах асуудалд төслийн бүх ажилчдын анхаарлыг хандуулах;
- Аюултай бодисын тээвэрлэлт – аюултай бодисын тээвэрлэлт, аюултай бодис асгарах тохиолдлын хор уршгийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахтай холбоотой үндэсний хууль тогтоомж болон олон улсын шаардлагыг хангах журмыг боловсруулах;
- Өвчнөөс урьдчилан сэргийлэх - халдварт өвчний тархалт болон тохиолдлоос урьдчилан сэргийлэх, түүнчлэн тандалт судалгаа хийх, ажилчдыг эмнэлгийн үзлэгт идэвхтэй хамруулж эмчлэх, орон нутгийн иргэдэд эрүүл мэндийн талаар ойлголт мэдлэг өгөх сургалтуудыг явуулах, эрүүл мэндийн үйлчилгээгээр хангах; ба
- Онцгой байдлын үеийн бэлэн байдал болон хариу арга хэмжээ, түүнчлэн харилцаа холбооны систем, олон нийтэд зарлан мэдээлэх, хэвлэл мэдээлэл болон асуудал эрхэлсэн агентлагуудтай харилцах, эмнэлгийн үйлчилгээ гэх мэт шаардлагатай арга хэмжээг багтаасан Онцгой байдлын үеийн бэлэн байдал болон хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах.

Европын сэргээн босголт, хөгжлийн банк

ЕСБХБ-ны гүйцэтгэлийн шаардлага 4 буюу “Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдал” нь орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдалтай холбоотой шаардлагуудыг тусгасан байдаг. Оюу толгой нь бодлогоо хэрэгжүүлэхдээ ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлага 4-ийг мөрдлөг болгоно.

Дараах үндсэн шаардлагууд орсон байдаг.

² Эх сурвалжийн URL:

[http://www.ifu.org/ifuext/sustainability.nsf/AttachmentsByTitle/gui_EHSGuidelines2007_GeneralEHS_3/\\$FILE/3+Community+Health+and+Safety.pdf](http://www.ifu.org/ifuext/sustainability.nsf/AttachmentsByTitle/gui_EHSGuidelines2007_GeneralEHS_3/$FILE/3+Community+Health+and+Safety.pdf)

Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-ПЛН-0001-М	Хувилбар: 1.3

- Төслийн зураг төсөл, барилга, ашиглалт болон төслийг хаах явцад нөлөөлөлд өртсөн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй эрсдлийг тогтоож үнэлэх бөгөөд тодорхойлсон нөлөөлөл болон эрсдэлтэй тохирохуйц урьдчилан сэргийлэх арга хэмжээ бүхий төлөвлөгөө гаргана. Эдгээр арга хэмжээнүүд нь нөлөөллийг бууруулах болон багасгахад чиглэсэн байхаас илүүтэйгээр урьдчилан сэргийлэх эсвэл зайлсхийхэд чиглэсэн байна.
- Уг төслийн буюу төслийн үе шатны үйл ажиллагаанаас нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа ба аюулгүй байдалд бодит эрсдэл учрах эсвэл сөрөг нөлөө үзүүлэх болзошгүй нөхцөл үүсвэл Төслийн холбогдолтой мэдээллийг нөлөөлөлд өртсөн иргэд, Засгийн газрын холбогдох байгууллагуудад мэдээлж, тэдэнд эдгээр эрсдэл, болзошгүй нөлөөллийн талаар болон санал болгож буй урьдчилан сэргийлэх, бууруулах ба яаралтай тусламжийн арга хэмжээний талаар ойлголт өгөх.
- Хариу арга хэмжээг тогтмол эргэн хянаж, Засгийн газрын агентлагууд болон нөлөөлөлд өртсөн иргэдийг байнга оролцуулж, хүлээсэн үүрэг ба төлөвлөгөөнүүдийн хэрэгжилтийн талаар тэдэнд мэдээлж, өөрчлөлт оруулахаас өмнө эдгээр төлөвлөгөөнүүдэд оруулах аливаа өөрчлөлтүүдийн талаар тэдэнтэй хэлэлцэх.
- Төслийн эрсдэл, болзошгүй нөлөөлөл болон давуу тал зэргийн тухай болон үйл ажиллагааны аливаа төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол (жишээ нь жил бүр) ЕСБХБ-д болон Гүйцэтгэлийн шаардлага 10-т тусгагдсан оролцогч талуудад тайлагнах тухай шаардлагын дагуу нөлөөлөлд өртсөн иргэдэд тайлагнах.
- Төслийн зураг төсөл хийх, барих, ашиглах, төслийн дэд бүтцийн хэсгээс татан буулгах зэрэг үйл ажиллагаануудыг салбарын олон улсын сайн туршлагын дагуу явуулах ба байгалийн гамшигт өртөх аюулыг, ялангуяа нөлөөлөлд өртсөн иргэдийн ашигладаг төслийн барилга байгууламж дээр гарсан ослын улмаас иргэдэд шууд болон шууд бус гэмтэл учруулах боломжтой эсэхийг онцгой анхаарах.
- Нийтийн эзэмшлийн замаар зорчих тээврийн хэрэгсэлтэй холбогдон гарч болох осол аваараас урьдчилан сэргийлэх арга зам хайх.
- Түүхий эд болон хог хаягдал тээвэрлэх, устгах ажлын аюулгүй байдлыг хянах зорилгоор бодит байдалд нийцсэн зардал бүхий хүчин чармайлт гаргаж, иргэд аюулд өртөхгүй байх эсвэл хянах арга хэмжээ авна. Эрсдэл, хүн ам аюулд өртөх, хариу арга хэмжээ, хяналт шинжилгээний тухай мэдээллээр холбогдох байгууллага, олон нийтийг хангана.
- Төслийн үйл ажиллагааны улмаас агаар, ус, хөрс, ургамал, амьтан болон нөлөөлөлд өртсөн иргэдийн ашигладаг байгалийн нөөцөд нөлөөлөх сөрөг нөлөөллөөс зайлсхийх, бууруулах.
- Төслийн ажиллах хүчнээс (үүнд мөн гэрээт гүйцэтгэгчид багтана) дамжих болзошгүй халдварт өвчнийг тодорхойлох. Шаардлагатай нөхцөлд, төслийн үйл ажиллагааны улмаас гарч болзошгүй халдварт өвчинд нутгийн иргэд, төслийн ажилчид өртөхөөс урьдчилан сэргийлэх буюу нөлөөллийг багасгах хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах.
- Үйлдвэрлэлийн тасалдал, гэнэтийн осол, онцгой байдал үүссэн нөхцөлд гарч болзошгүй үйл ажиллагааны эрсдэл болон түүний болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд авахад бэлэн байх.
- Хүн болон байгаль орчныг хамгаалахад тууштай, үр дүнтэй зарчим баримталж том хэмжээний ослын аюулыг тодорхойлж, уг ослоос урьдчилан сэргийлэх бүх

Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-PLN-0001-М	Хувилбар: 1.3

талын арга хэмжээг авч, түүний хүн, байгаль орчинд нөлөөлөх хор уршгийг багасгах.

- Онцгой байдал үүссэн нөхцөлд үр дүнтэй арга хэмжээ авах, хор уршгийг багасгахын тулд орон нутгийн иргэд болон орон нутгийн засаг захиргааг дэмжих, тэдэнтэй хамтран ажиллах, ялангуяа үүссэн онцгой байдлыг хариу арга хэмжээ авахад тэдний оролцоо, хамтын ажиллагаа шаардлагатай тохиолдолд.
- Төслийн аюулгүй байдлын зохицуулалт хийх үед төслийн талбай буюу барилга байгууламжийн дотор ба гадна талд байгаа хүмүүст учирч болзошгүй эрсдлийг үнэлэх.
- Үйлчлүүлэгч нь харуул хамгаалалтын албан хаагчийн хууль бус үйл ажиллагаа болон ёс зүйгүй үйлдлийг магадлан судалж, дахин давтуулахгүй байх үүднээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч (эсвэл холбогдох талуудыг арга хэмжээ авахыг шаардах), шаардлагатай мэдээлэлийг орон нутгийн удирдлагад өгнө.

Хүний эрх болон аюулгүй байдлыг хангах тухай сайн дурын зарчмууд

Хүний эрх болон аюулгүй байдлыг хангах тухай сайн дурын зарчмууд (СДЗ) нь олборлох салбарын компаниудад хүний эрх, үндсэн эрх чөлөөг хангах зарчимд үндэслэн үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангаж ажиллах зааварчилгаа өгөх зорилгоор 2000 онд нэвтрүүлсэн.³ Сайн дурын зарчмууд нь дараах үндсэн гурван ангилалд багтдаг.

- Эрсдлийн үнэлгээ;
- Олон нийтийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой харилцаа;
- Хувийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой харилцаа.

Эрсдлийн үнэлгээ нь компанийн үйл ажиллагаа явуулж буй орчинд ажилчид, орон нутгийн иргэд болон хөрөнгийн аюулгүй байдал, түүнчлэн хүний эрх хамгаалахтай холбоотой гарах эрсдлийг үнэлдэг. Компанийн хувьд Засгийн газраас авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд, ялангуяа олон нийтийн хэв журам сахиулах үүрэгтэй байгууллагуудын үйл ажиллагаанд хүний эрхийг дэмжих, хамгаалах зарчмыг тууштай баримтлуулах сонирхолтой байдаг. Компанийн ажилчдыг эсвэл өмчийг хамгаалах үүрэгтэй харуул хамгаалалтын хувийн байгууллагын эрх мэдлээ хэтрүүлэх эрсдлийг багасгаж, бусдыг хүндэтгэх болон хүний эрхийг хүндэтгэх үндсэн зарчим баримтална.

4.5 Оюу толгой, Рио Тинто компаниудын холбогдох стандартууд

Оюу Толгой төсөл нь ажилчдын кэмпэд аюулгүй амьдрах орчин бүрдүүлэх зорилготой *Кэмпийн дотоод журам, ёс зүйн дүрмийг* мөн боловсруулна. Кэмпийн ажилчидтай холбоотой тодорхой шаардлагуудаас гадна тус дүрэмд кэмпээс гадагш тархаж, орон нутгийн иргэдэд⁴ нөлөөлж болзошгүй эрсдэлийг бууруулахад хувь нэмэр оруулах зүйл заалт орсон.

Хамтын ажиллагааны гэрээ

2011 оны 4-р сард Өмнөговь аймгийн Ханбогд сум, Оюу толгой ХХК-ийн хооронд Хамтын ажиллагааны өргөн хүрээний зорилтуудыг тусгасан Харилцан ойлголцолын санамж бичигт гарын үсэг зурснаар Хамтын ажиллагааны гэрээ хүчин төгөлдөр

³ Эх сурвалжийн URL: <http://www.voluntaryprinciples.org/principles/introduction>

⁴ Энэ журмын дагуу аливаа халдварт өвчний тухай мэдэгдэх хэрэгтэй ба зөвшөөрөлгүй хүн кэмпэд нэвтрэхийг чанд хориглодог.

Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-ПЛН-0001-М	Хувилбар: 1.3

мөрдөгдөж эхэлсэн. 2012 оны 9-р сард хэлэлцээр явуулах зарчим, үндсэн процессийг заасан Үйл явцын гэрээг байгуулсан. Дараа нь 2015 оны 4-р сарын 22-ны өдөр Өмнөговь аймаг, Ханбогд, Манлай, Баян-Овоо, Даланзадгад сумд болон Оюу толгой Хамтын ажиллагааны гэрээг байгуулсан.

Тус гэрээнд Өмнөговь аймаг, Ханбогд болон бусад түнш/хөрш зэргэлдээ сумдыг тогтвортой хөгжүүлэх чиглэлээр талууд хэрхэн хамтран ажиллах тухай заасан. Гэрээний дагуу талуудын сонирхож буй доорх чухал сэдвүүдийг тодорхойлсон:

- Усны менежемент – Нэмэлт хавсралт 4
- Байгаль орчны хяналт шинжилгээ, хамгаалалт – Нэмэлт хавсралт 5
- Уламжлалт мал аж ахуй, Бэлчээрийн газрын менежмент – Нэмэлт хавсралт 6
- Үндэсний түүх, соёл, аялал жуулчлал – Нэмэлт хавсралт 7
- Нийгмийн суурь үйлчилгээ (эрүүл мэнд, соёл, боловсрол, мэргэжлийн сургалт, хөдөлмөр эрхлэлт) – Нэмэлт хавсралт 8
- Орон нутгийн бизнесийн хөгжлийг дэмжих, тэдгээрээс бараа, үйлчилгээ худалдан авах – Нэмэлт хавсралт 9
- Нийтийн дэд бүтэц, хөрөнгө оруулалтын төслүүд – Нэмэлт хавсралт 10.

Нэмэлт хавсралт 8-д орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын чиглэлээр талуудын хүлээх үүргийг заасан:

- (a) Талууд Өмнөговь аймаг болон Түншлэгч сумдын эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх зорилго бүхий бүх төлөвлөгөө, бодлого, төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд хамтран ажиллахыг зөвшөөрч байна.
- (b) Өмнөговь аймаг нь орон нутгийн эрүүл мэндийн үйлчилгээний салбаруудын чанар, хүрэлцээ, хүртээмжийг сайжруулахад салбар хоорондын хамтын ажиллагаанд манлайлж оролцоно
- (c) Талууд халдварт болон халдварт бус өвчинтэй холбоотой эрсдлийг бууруулахад дэмжих зорилгоор холбогдох бусад талууд болон эрүүл мэндийн байгууллагатай хамтран ажиллахыг зөвшөөрч байна
- (d) Өмнөговь аймаг болон Түншлэгч сумд нь ажилтнуудын эрүүл мэндийг сайжруулахад дэмжлэг үзүүлэхээр бол ОТ ХХК нь ажилтны эрүүл мэндийн талаарх мэдээллийг Өмнөговь аймгийн эрүүл мэндийн эрх бүхий байгууллагуудад гаргаж өгөх талаар авч үзэх бөгөөд энэ нь тухай бүр ОТ ХХК-ийн хуулийн дагуу хүлээсэн үүргүүд болон мэдээллийн нууцлалын бодлогуудад нийцсэн байна.
- (e) ОТ ХХК нь Өмнөговийн эмнэлгийн эмч нар, эрүүл мэндийн салбарын мэргэжилтнүүдэд англи хэлний чадвар олгох сургалт болон Өмнөговийн эрүүл мэндийн салбарын боловсон хүчнийг чадавхжуулах талаар дэмжлэг үзүүлж болно.
- (f) Талууд авто замын аюулгүй байдлын талаарх ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор хамтран ажиллахыг зөвшөөрч байгаа бөгөөд ОТ ХХК нь авто замын аюулгүй байдлын хөтөлбөрүүдийг боловсруулж, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Түншлэгч сумдын цагдаагийн алба, албан хаагчидтай шууд хамтран ажиллана.

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-PLN-0001-M	Хувилбар: 1.3

- (g) ОТ ХХК нь Түншлэгч сумдын нийтийн зориулалттай авто замын аюулгүй байдлын талаарх хөтөлбөрүүдийг өөрийн ажилтнууд, гэрээт гүйцэтгэгчдэд ойлгуулан таниулах, тэдгээр хөтөлбөрүүдийн сурталчилгааг боломжтой газруудад зохион байгуулна.
- (h) Талууд нь Түншлэгч сумдын оршин суугчдыг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор янз бүрийн практик мэдлэг олгох боловсролын үйл ажиллагаа, үзүүлэх сургалт болон бусад арга хэмжээг дэмжих үүднээс хамтран ажиллахыг зөвшөөрч байна. Боломжтой тохиолдолд ОТ ХХК нь замын хөдөлгөөний аюулгүй байдал, автомашины аюулгүй ажиллагааны сургалт, боловсролын үйл ажиллагаанд өөрийн жолооч нарыг оролцуулна.
- (i) ОТ ХХК нь Харилцааны хороонд болон орон нутгийн онцгой байдлын албад, Түншлэгч сумдын цагдаагийн байгууллага, сумын захиргааны байгууллагуудад ОТ ХХК-ийн гамшиг, ослын үед авах шуурхай арга хэмжээний төлөвлөгөө, журмын талаар жил бүр товч мэдээлэл хийнэ
- (j) Талууд Түншлэгч сумдын гамшиг, ослын үед болон зам тээврийн ослын үед авах шуурхай арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор хамтран ажиллахыг зөвшөөрч байна.
- (k) Талууд тээврийн хэрэгслийг аюулгүй ажиллуулах, халдварт өвчин (тухайлбал, БЗХӨ, ХДХВ болон сүрьеэ), архи болон мансууруулах бодисын хэрэглээг хязгаарлах, сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, хүйсийн болон гэр бүлийн хүчирхийлэл, амиа хорлолтоос урьдчилан сэргийлэх, хоол хүнсний тэжээллэг чанар, амьдралын хэв маяг болон бие бялдрыг чийрэгжүүлэх үйл ажиллагаа зэргийг оруулан Түншлэгч сумдын эрүүл мэндийн талаарх кампанит ажлуудад дэмжлэг үзүүлэх үүднээс хамтран ажиллахыг зөвшөөрч байна.
- (l) Талууд Ханбогд суманд малчид болон орон нутгийн бусад гишүүдийн эрүүл мэндийн асуудлаар судалгаа явуулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор хамтран ажиллахыг зөвшөөрч байна.
- (m) ОТ ХХК нь өөрийн шийдвэрт үндэслэн SOS Эмнэлэг болон эрүүл мэндийн ажилтнуудаараа дамжуулан орон нутгийн оршин суугчдад яаралтай түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэх, эмнэлэгийн нүүлгэн шилжүүлэлтэд тусалцаа үзүүлэх, эмнэлэгийн тоног төхөөрөмжийг ашиглах бололцоо олгох болон Ханбогдын эмнэлэгийн ажилтнуудыг дадлагажуулах болон тэдэнд сургалт явуулж болно. Эдгээр үйл ажиллагааг Харилцааны хороонд жил бүр тайлагнана.

Оюу толгой нь гэрээний дагуу, Оюу толгой болон Орон нутгийн хамтран байгуулж, Өмнөговь аймагт хэрэгжүүлэх орон нутгийн төсөл, хөтөлбөрт бие даан дэмжлэг үзүүлэн ажилладаг “Говийн оюу” хөгжлийг дэмжих санд жил бүр хандив олгоно.

ОТ-н Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын хөтөлбөрүүдийг ихэнхи тохиолдолд Хамтын ажиллагааны гэрээний дагуу хэрэгжүүлж, орон нутгийн байгууллага, орон нутгийн иргэдийг чадваржуулах замаар тогтвортой хөгжлийг дэмжинэ.

2015 онд Нийгмийн харилцааны хэлтэс төслийг хэрэгжүүлэхээс зорилтоос орон нутгийн иргэдийг чадваржуулах чиглэлд шилжиж, удирдлагын хяналтын хэрэгжилтийн механизмыг өөрчилсөн. Улмаар дараах гол зарчмуудыг дагаж мөрдөнө:

Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-PLN-0001-М	Хувилбар: 1.3

- Илрүүлсэн, шууд, сөрөг нөлөөг бууруулах удирдлагын хяналтыг ОТ хэрэгжүүлэх бөгөөд үүнийг ОТ дангаараа хариуцна.
- Ирээдүйн нөлөөллөөс урьдчилан сэргийлэх төсөл, хөтөлбөрийг Хамтын ажиллагааны гэрээ болон ХДС-гаар дамжуулан удирдан зохицуулна (үр дүнг БОНБДХ-аар хянан шалгана).
- Удирдлага хяналтын арга хэмжээг хэрэгжүүлээгүй, Хамтын ажиллагааны гэрээ, ХДС-гийн аль ч хөтөлбөрийн хүрээнд хангалттай шийдвэрлэж чадаагүй ирээдүйд учрах аливаа шууд сөрөг нөлөөллийг ОТ хариуцна.

Рио Тинтогийн Орон нутаг, нийгмийн харилцааны стандарт

Рио Тинтогийн *Орон нутаг, нийгмийн харилцааны стандартад* доорх багтана:

- орон нутгийн иргэдийн тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал, эрүүл мэнд, амьжиргааг дэмжих санаачлагыг дэмжихэд чиглэнэ.
- Аюулгүй байдал, хүний эрхийг хангах тухай сайн дурын зарчмуудын хэрэгжилт.

Рио Тинто компанийн хүний эрхийн удирдамж

Рио Тинто⁵ компанийн боловсруулсан хүний эрхийн удирдамж нь Нэгдсэн үндэсний байгууллагын (НҮБ) Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын гэрээ (ИУТЭТОУП), Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын гэрээ, НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн даргын Даян дэлхийн тунхаг, Хүний эрх аюулгүй байдлыг хангах тухай сайн дурын зарчмуудад үндэслэсэн. Рио Тинто компанийн харуул хамгаалалтыг ашиглах тухай журам нь хүний эрхийн зарчимд үндэслэсэн бөгөөд үүнд хүч хэрэглэх болон хязгаарлах талаарх удирдамж багтана. Эдгээр журмыг гэрээт харуул хамгаалалтын албан хаагч болон бүх ажилчдад байнгын сургалтаар дамжуулан мөрдлөг болгодог. Хүний эрхийн хэм хэмжээг мөрдөхийн тулд дараах журмыг баримтална.

- Хамгаалалтын албаны ажилтнуудыг ажилд авахаас өмнө сайтар судлах.
- Харуул хамгаалалтын албан хаагчид өөрийн өдөр тутмын үйл ажиллагаандаа хүний эрхийг хүндэтгэх ёстой. Үүнд ямар нэг байдлаар арьс өнгөөр ялгаварлан гадуурхах, хүний хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцох болон ёс зүйгүй, хүнийг доромжилсон аливаа хандлага гаргахаас зайлсхийх зэрэг багтана.
- Харуул хамгаалалтын албан хаагчид нь зөвхөн гарцаагүй шаардлагатай тохиолдолд хүч хэрэглэх бөгөөд энэхүү үйл ажиллагааг ямагт хууль тогтоомжийн дагуу явуулна.
- Хүч хэрэглэснээс үүдэн Компанийн үйл ажиллагаа болон орон нутгийн иргэдийн хооронд үл итгэлцэл үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор нутгийн ард иргэдтэй хэлэлцүүлэг тогтмол хийж, аюулгүй байдлын дүрэм журмыг олон нийтэд нээлттэй болгож, харуул хамгаалалтын албан хаагчидтай холбоотой санал гомдлыг түргэн шуурхай хүлээн авч, зохих журмын дагуу хариу өгөх нэн чухал.

⁵ Бидний ажлын арга барил баримт бичигт тодорхойлсон хүний эрхийн бодлогыг хэрэгжүүлэхдээ менежерүүдийн баримталж ажиллах удирдамж Рио Тинто компани, 2003 оны 10-р сар Эх сурвалжийн URL: http://www.riotinto.com/documents/ReportsPublications/corpPub_HumanRights.pdf

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-PLN-0001-М	Хувилбар: 1.3

Эдгээр зарчмуудыг мөрдүүлэхийн тулд харуул хамгаалалтын албан хаагчийн сургалтыг зохион байгуулдаг. Эдгээр бүх зарчмууд нь хамгаалалт хариуцсан гүйцэтгэгч нарт адил тэгш хамаарах бөгөөд компанитай бизнес хийх онцгой нөхцөл болно.

4.6 Оюу толгой компани мөрдөхөөр үүрэг амлалт авсан салбарын бусад удирдамжууд

Рио Тинто компани олон улсын үүрэг амлалт, хэм хэмжээнүүдэд гарын үсэг зурж баталсан бөгөөд эдгээр шаардлагыг биелүүлэхийн төлөө ажилладаг. Компани нь *Хүний эрх, аюулгүй байдлыг хангах сайн дурын зарчмуудыг*⁵ боловсруулах үед оролцож, энэхүү зарчмуудыг анх 2000 онд тунхагласнаас хойш дэмжиж ирсэн. Рио Тинто компани *НҮБ-ын Даян дэлхийн тунхагийг*⁶ (*Олон улсын стандарт, конвенци гэсэн хэсэг 17.5.3-ыг үзнэ үү*) үндэслэгчдийн нэг бөгөөд Их Британи Умард Ирландын нэгдсэн вант улсын сүлжээ болон харилцаа холбоог сайжруулах ажлын хэсгийн идэвхитэй гишүүн юм. Рио Тинто компанийн харилцаа холбооны явцын талаарх мэдээ компанийн цахим хуудсанд жил болгон нийтэлдэг. Рио Тинто компанийн хүний эрхтэй холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг компанийн цахим хуудаснаас авч болно.

4.7 Төслийн холбогдох стандартуудын хураангуй

Оюу Толгой компани зээлдүүлэгчийн холбогдох стандарт, Рио Тинто компанийн холбогдох стандарт болон үндэсний стандартуудыг мөрдөх болно.

Төслийн холбогдох стандартын хураангуйг доор харуулав.

Холбогдох стандартуудын хураангуй

Стандарт	Хамрах хүрээ
Рио Тинто компанийн Орон нутаг, нийгмийн хариуцлагын асуудалд баримтлах стандарт (2015)	Орон нутгийн иргэдэд нэн түрүүн тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх эрүүл мэнд, амьжиргаа дэмжих санаачилгыг дэмжих.
ОУСК-ын Гүйцэтгэлийн стандарт 4: Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал	Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдалтай холбоотой эрсдлийн үнэлгээ, хариу арга хэмжээ ба менежмент
ЕСБХБ-ны Гүйцэтгэлийн шаардлага 4: Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал	Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдалтай холбоотой эрсдлийн үнэлгээ, хариу арга хэмжээ ба менежмент
Хүний эрх болон аюулгүй байдлыг хангах тухай сайн дурын зарчмууд	Ажилчид, орон нутгийн иргэд, эд хөрөнгө, мөн хүний эрхийг хамгаалахтай холбоотой аюулгүй байдлыг хангах арга хэмжээний эрсдлийн үнэлгээ ба менежмент

⁶ www.unglobalcompact.org

Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-ПЛН-0001-М	Хувилбар: 1.3

5 НӨЛӨӨЛӨЛ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ БА УДИРДЛАГЫН ХЯНАЛТУУД

5.1 Хураангуй

Энэ баримт бичиг нь Оюу Толгой компанийн Оюу Толгой төслийн шууд болон шууд бус нөлөөллөөс үүдэн гарч болох орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын эрсдлийг бууруулах үүрэг, арга барилыг тодорхойлно.

2010-2011 онд *Орон нутгийн иргэдийн эрүүл мэндэд нөлөөлөх байдлын үнэлгээ (ЭМНБҮ)* хийснээс хойш ОТ Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын нөлөөллийн удирдлагын төлөвлөгөөг хэрэгжүүлж, хөтөлбөрийн үр дүн, нөлөөллийн тасралтгүй хянаж ирсэн. Гүний уурхайн бүтээн байгуулалттай холбоотойгоор Орон нутаг, нийгмийн харилцааны хэлтэс 2015 онд нийгмийн нөлөөллийн бүртгэлд үндэслэн нийгмийн эрсдлийн үнэлгээ, GAP шинжилгээ хийсэн.

Нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээгээр, нийгэмд нөлөөлөх байдлын GAP шинжилгээгээр ялангуяа Ханбогд болон, Даланзадгадад үүсч байгаа хүн амын шилжилт хөдөлгөөнтэй холбоотойгоор үүсэх болзошгүй сөрөг эрсдлийг тодорхойлсон. Орон нутагт дэд бүтэц хөгжөөгүй, эрүүл мэнд, нийгмийн бусад үйлчилгээ хүрэлцэхгүй байгаа нь байдлыг улам хурцатгах юм. Судалгаагаар хамгийн чухал эрсдэлд дараах эрсдлүүдийг тодорхойлсон. Үүнд:

- Хүн ам хэт төвлөрч нягтрал ихсэх, ариун цэвэр эрүүл ахуйн нөхцөл дордох нь халдварт өвчин, нийгмийн зөрчилтэй холбогдоно “илүү ойр оршин суух”, бохир нөхцөл
- согтууруулах ундааг ихээр хэрэглэх нь согтууруулах ундааны хурц хордлого, архаг өвчин, гэр бүлийн дарамт, гэмтэл, хүчирхийлэлтэй холбогдоно
- Биеэ үнэлэх, аюултай бэлгийн хавьталт ихсэх нь ялангуяа гэр бүл салалт, бэлгийн замаар дамжих халдвар (БЗДХ) ихсэх, ХДХВ-ийн эрсдэлтэй холбогдоно.
- Тээврийн хэрэгсэл (ачааны машин, хөнгөн тэрэг, мотоциклийг оролцуулан) олшрох, автозамын чанар хангалтгүй, суурин газраас ачааны хүнд оврын машины хөдөлгөөний нягтрал ихтэй замууд холгүй өнгөрч байгаа, болгоомж сэрэмжгүй явган зорчигч, замын хөдөлгөөний дүрмийн хэрэгжилт хангалтгүй, тээврийн хэрэгслийн үзлэг хяналт хангалтгүй, жолооч нарын ур чадвар хангалтгүй, согтуугаар эсвэл ядарсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодох явдал ихэссэнээс зам тээврийн осол гэмтэлээс шалтгаалан бэртэж гэмтэх, тахир дутуу болох, эндэх явдал ихсэх.

Дээр дурдсан хариу арга хэмжээ авах шаардлагатай сөрөг нөлөөллөөс гадна уурхайн явуулж үйл ажиллагааны хүрээнд орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлыг сайжруулах боломж байна. Үүнийг (Шилжилт хөдөлгөөний удирдлагын төлөвлөгөөгөөр, дамжуулан) дэмжих арга хэмжээг авснаар ашиг орлого нэмэгдэж, хүнсний барааны хангамж сайжрахад уурхайн нөлөөллийн хүрээний иргэд илүү сайн орон сууцанд амьдарч, амьдрах нөхцөл нь сайжирч, илүү шим тэжээлтэй хүнсээр хооллох нөхцөл бүрэлдэнэ. Мөн хүн амын нягтаршил ихсэж, хүн амын тоо нэмэгдсэнээр давуу тал бий болно хэмээх хүлээлт байна. Эрүүл мэнд, боловсрол, хууль эрх зүй зэрэг чиглэлийн төрийн үйлчилгээ чанартай болсноор эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал сайжрах юм. Цаашилбал хүн ам ихсэж, чадавхи

ОЮУ ТОЛГОЙ ХХК

Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-ПЛН-0001-М	Хувилбар: 1.3

бэхжүүлэх стратегийг хэрэгжүүлснээр илүү олон хувийн эмнэлэг бий болох боломжтой.

Дор тайлбарласан хяналтын арга хэмжээ болон ОНЭМАААБ-ын хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. 2018-2020 онд Өмнөговь аймаг, НҮБ-ын Хүн амын сан болон Оюу толгой ХХК-ны хооронд 2018 оны 4 сарын 12-нд нээлтээ хийсэн “Өмнөговь аймгийн эмэгтэйчүүд залуучуудын эрүүл мэндийг дэмжих төсөлд” (2018-2021) хамрагдсан төлөвлөгөөт ажлуудыг хэрэгжүүлж байна. Энэ хөтөлбөрийг Өсвөр үе хүүхэд залуучуудад ээлтэй эмнэлэг, Залуучуудын хөгжлийн төв болон бусад залуу бизнес эрхлэгчид, залуу малчид, залуу үеийнхнийг дэмжих хөтөлбөрийн эхний шатанд хэрэгжсэн томоохон ололт амжилтанд тулгуурлаж санаачилсан юм.

Энэ хөтөлбөр нь "Өмнөговь аймгийн хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүдийн эрүүл мэндийг сайжруулах" –ахад бүхэлдээ чиглэж ажиллана. Дараах зорилтыг хангаж ажиллана. Үүнд:

- Залуучүүд, өсвөр насны хүүхэд, эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн болон бэлгийн эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах
- Бэлгийн замын халдварт өвчин, умайн хүзүүн хорт хавдарыг бууруулах
- Замын бэртэл гэмтлээс үүдэлтэй сэтгэцийн эмгэг, умайн хүзүүний хорт хавдар зэрэг халдварт бус өвчлөлийг бууруулах
- Бүсийн хэмжээний засаглал, чадавх бэхжүүлэх
- Өсвөр насны хүүхэд, залуучуудын шийдвэр гаргах түвшний оролцоог сайжруулах
- Хүйсийн хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэлийг бууруулах хүчин чадавхийг бэхжүүлэх

Болзошгүй нөлөөлөл	Удирдлагын хяналт	Үр дүн
Халдварт өвчин нэмэгдэх	<i>Эрүүл мэндийн халамжийн зохицуулалтад халдварт өвчнөөс сэргийлэх</i>	
	ХБ, ДЗ, МЛ, БО сумдын эмч мэргэжилтний дунд цусаар дамжих халдварын тархалтын судалгаа (2011-2012)	<ul style="list-style-type: none"> - ХБ, ДЗ, МЛ, БО сумдын эрүүл мэндийн/эмнэлгийн ажилтнуудад дамжих халдварын талаар ойлголттой болгох (тархалтын тооцоо, эрсдлийн хүчин зүйлийн үнэлгээ) - Ажлын байранд нөлөөлөлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, удирдан зохицуулах үр дүнтэй аргын талаар санал зөвлөмж гаргах - МУ-ын өндөр эрсдэлд ажилладаг эрүүл мэндийн ажилтнуудын дунд цусаар дамжих халдварын тархалтын үндэсний хэмжээний судалгаа явуулах - Эрүүл мэндийн ажилтнууд цусаар дамжих халдварын талаар цогц мэдлэгтэй болно
	Сумын эрүүл мэндийн ажилтнуудын элэгний В гепатитын вакцинжуулалт (2012)	<ul style="list-style-type: none"> - Эрүүл мэнд, эмнэлгийн ажилтнуудыг хамгаалах - Эмнэлгийн орчинд В гепатитын халдвар тараахаас сэргийлэх

Орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдлын удирдлагын төлөвлөгөө		
Хүчин төгөлдөр болох огноо: 2013.09.01	Баримт бичгийн дугаар: ОТ-10-PLN-0001-М	Хувилбар: 1.3

Эмнэлгийн хог хаягдлын удирдлага – тоног төхөөрөмжийн хангамж (2012-2013)	<ul style="list-style-type: none"> - ХБ, БО, МЛ, ДЗ-д үндэсний стандартад нийцсэн илүү сайн эмнэлгийн хаягдлын удирдлага бүхий эмнэлгийн барилга байгууламжтай болно - Эмнэлгийн хаягдлын барилга байгууламжийн талаарх ойлголт, мэдлэг, нийлүүлсэн тоног төхөөрөмжийг ашиглах ур чадвар сайжирна
